

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч, Батсуурь Дуламсүрэн

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Сургуулийн орчин дахь хүүхдийн хөгжил, хамгаалал, орчны аюулгүй байдлыг хангах, багш, ажилтан, суралцагч, олон нийт, эцэг, эх асран хамгаалагчдын оролцоог дэмжих							
1	Нэг ээлжээр хичээллэх сургуулийн сургалтын зохион байгуулалт, сургалтын төлөвлөгөөний төсөл боловсруулж турших	Сургалтын төлөвлөгөөний хувилбар, төсөл	-	Нэг ээлжээр хичээллэх сургуулийн сургалтын төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна.	Нэг ээлжээр хичээллэх сургуулийн хичээл сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах загварын төслийг боловсрууллаа. Уг төслийг боловсруулахдаа “Писа-2023”, “Боловсролын биет орчин, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах зөвлөмж” тайлангуудтай танилцсан бөгөөд боловсролын үр дүнгийн чанар, тэгш байдлыг сайжруулахын тулд суралцагчдын сургалтын цаг ашиглалтыг	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					оновчтой болгох, шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх ёстойг чухалчилсан байна. Энэхүү хэрэгцээ, шаардлагад үндэслэн суралцагчдын сургууль дээр өнгөрөөх цагийг нэмэгдүүлж, тэдний хамтдаа суралцах, хөгжих, сайн сайхан байдлыг нь дэмжихэд чиглэсэн төлөвлөлтийн төслийг боловсруулсан бөгөөд 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн туршихаар ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
2	Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал төлөвлөх, хуваарилах заавар боловсруулна.	Зааврын төсөл	-	Зардал төлөвлөх, хуваарилах заавар боловсруулж, батлуулсан байна.	УИХ-ын 2023 оны нэгдсэн чуулганаар батлагдсан Боловсролын ерөнхий хуулиар “Боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт”-ийн зардлын бүрэлдэхүүнд сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын зардлыг багтаасан. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын зардлыг төлөвлөх,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					зарцуулах заавар"-ын төслийг боловсруулж, сургуулийн нийгмийн ажилтнуудын төлөөлөл, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн болон Боловсролын ерөнхий газрын холбогдох газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг оролцуулан 3 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжийг тусган эцэслэж, Санхүүгийн хэлтэст хүлээлгэн өгсөн. Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолд өөрчлөлт орсонтой холбоотой Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар батлуулах ажил хүлээгдэж байгаа талаар Санхүүгийн хэлтсээс мэдээлэл өгсөн. Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын зардлыг сургуулийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаа, эрсдэлийн үнэлгээнд суурилан төлөвлөх бөгөөд хүүхэд хамгааллын зардлын төсвийн 50-аас доошгүй хувийг урьдчилан сэргийлэх үйл		
--	--	--	--	--	--	--	--

					ажиллагаанд, 30 хүртэлх хувийг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд, 20 хүртэлх хувийг шуурхай тусламжийн үйлчилгээнд зарцуулахаар тусгалаа. Энэхүү заавар батлагдсанаар сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй суралцагчийг илрүүлэх, эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, тэдний аюулгүй байдлыг хангах, хүүхэд хамгааллын холбогдох байгууллагад мэдээлэх, хүчирхийллийн хохирогч, холбогдогч суралцагчийг нөхөн сэргээх, чадавхжуулах, дахин хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэхэд чиглэсэн үйлчилгээ, үйл ажиллагааг чанартай, хүртээмжтэй хүргэх боломж бүрдэнэ. Хавсралт: 1 файл		
3	Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаанд хамрагдах хүртээмжийг нэмэгдүүлэх цахим	Цахим систем	2700 суралцагч хамрагдсан.	Цахим системээр дамжуулан хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны хүртээмжийг	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсэгт “Суралцагчийн суралцах үйл ажиллагаа,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	систем /after school/-ийг нэвтрүүлнэ.			нэмэгдүүлсэн байна.	хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны салшгүй хэсэг байна.” гэж заасан. 2023-2024 оны хичээлийн жилд төрийн өмчийн ерөнхий боловсролын 695 сургуульд 701,065 суралцагч суралцаж байгаагаас сургууль дээрх хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа, секц, дугуйланд давхардсан тоогоор 420,639 суралцагч буюу нийт суралцагчдын 60% нь хамрагдаж байна. Орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцагчийг хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаанд тэгш, хүртээмжтэй оролцуулах зорилгоор Equity Lab ТББ-тай хамтран “After school” цахим систем /аппликейшн/-ийг нэвтрүүлж дэлхийн иргэний боловсрол, мэргэжил сонголттой холбогдох 8 чиглэлийн	сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---------------------------------------	--	--	---------------------	--	--	---

					30 төрлийн хичээлээс сонгон сургалт, үйл ажиллагаанд хамрагдах боломжийг бүрдүүллээ. Энэхүү “After school” цахим систем нь ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан хүүхдийн өсөлт хөгжлийн цогц платформ бөгөөд хичээлээс гадуурх цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, өсвөр насанд зориулсан менторшип, коучинг, сэтгэлзүйн зөвлөгөөг ганцаарчилж авах, нийгэм, хүрээлэн буй орчныхоо сайн сайхны төлөө хийж буй сайн дурын ажил, санаачлагаараа хийсэн эерэг үйлдлүүдээ бүртгэлжүүлж, урамшуулал бэлэг авах боломжтойгоороо ач холбогдолтой юм. Цахим системд 2,300 нийгмийн ажилтан, 49,337 суралцагчийг хамруулж, хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүллээ. Хавсралт: 1 файл		
--	--	--	--	--	---	--	--

4	“Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтэд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.	Төлөвлөгөө, батлагдсан тушаал	Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоол	“Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан байна.	Эрүүл мэндийн сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны А/27/А/25 дугаар хамтарсан тушаалаар “Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоол, “Эрүүл шүд” төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр ерөнхий боловсролын 183 сургууль улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хөрөнгө оруулалт, эцэг эхчүүдийн дэмжлэг (53.3 сая төгрөг)-ээр шүд угаах цэг байгуулсан байна. Мөн 186 сургууль шүд угаах цагийн зохицуулалт хийж бага ангийн суралцагчид их завсарлагааны үеэр шүд угаах боломжтой болсон. Ерөнхий боловсролын сургуулийн 13.2 хувь буюу 123 сургууль улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр, төрийн бус байгууллагын санхүүжилтээр амны хөндийн эрүүл ахуйн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	---	-------------------------------	--	---	--	--	--

					үзүүлэн, макет зэрэг хэрэглэгдэхүүнээр хангагдсан. Шүд, амны хөндийн эрүүл мэндийн сургалтад 21 аймаг, 9 дүүргийн 331,459 суралцагч хамрагдсан бөгөөд 315,735 суралцагч шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсанаас 54,880 суралцагчийн шүдийг эрүүлжүүлж, 20,429 суралцагч сургуулийн орчинд шүдээ угааж хэвшсэн байна. Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих сургалт, үйл ажиллагааг 527 сургууль зохион байгуулж 136558 эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулсан. Хавсралт: 2 файл		
5	“Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн судалгаа-2023” судалгааны үр дүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж боловсруулна.	Зөвлөмж	Судалгааны тайлан	Санал боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна	Хүүхдийг аливаа болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний аюулгүй байдлыг хангахад тэргүүлэх чиг үүрэг бүхий Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам хамтран “Боловсролын	1-р сар, 2-р сар, 3-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн

					орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн судалгаа” үндэсний түүвэр судалгааг ерөнхий боловсролын сургуульд суурилан 13-17 насны суралцагчдын оролцоотой зохион байгуулж, үр дүнг үндэсний түвшинд тархаасан. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 27,2 хувь буюу 4 суралцагч тутмын 1 нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд сургуулийн орчинд /сургуулийн коридор, анги, хичээлийн танхим, ариун цэврийн өрөө, биеийн тамирын заал гэх мэт хүүхэд олноор цуглардаг газар/ аюулгүй байдал алдагдсан, 38,8 хувь буюу 5 суралцагч тутмын 2 нь сургуульд ирж, буцахдаа ямар нэг тээврийн хэрэгслээр зорчдог, эмэгтэй суралцагчдын 64.0 хувь нь сургуульдаа ирж, буцахдаа гэрлэн дохионы ажиллагаагүй байдал, халтиргаатай зам, гэрэлтүүлэггүй гудамж, архи уудаг хүмүүс цуглардаг газар, нохой, автомашины	байдал: 100%
--	--	--	--	--	---	--------------

					хөдөлгөөнөөс эмээх зэрэг саад бэрхшээлтэй тулгардаг, 3 суралцагч тутмын 1 нь сургууль дээрээ үе тэнгийнхний дээрэлхэлтэд өртөж байсан гэсэн үр дүн гарсан. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хүчирхийлэл, хорт зуршил, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах зөвлөмжийг боловсруулж, БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 2/1017 тоот албан бичгээр БШУГ-т хүргүүлж, хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиглэлийг өгсөн. Хавсралт: 1 файл		
6	Хүүхдийн эрсдэлийг үнэлэх үнэлгээний аргачлал боловсруулна.	Аргачлал	-	Аргачлал боловсруулсан байна.	УИХ-ын 2024 оны 1 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 23 дугаар зүйлийн 23.2-т “хичээлийн жилийн турш хүүхэд эрсдэлт нөхцөлд	4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ

					байгаа эсэхийг үнэлэх, зөвлөгөө өгөх, хүүхэд бүрийн нийгэм, сэтгэл зүйн асуудлыг илрүүлэх, тандан судлах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх.” гэж тусгасан. Хүүхдийн эрсдэлийг тодорхойлж, нөхцөл байдлыг үнэлэн, цаашид үзүүлэх үйлчилгээг тодорхойлох зорилгоор “Хүүхдийн эрсдэлийг үнэлэх үнэлгээний маягт”-ыг боловсруулж, ХНХЯ-тай хамтарсан хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хавсралт: 1 файл		төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
7	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал зүйл)-ийг УИХ-ын хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлнэ.	Хууль	Засгийн 2023 оны 10 сарын 13-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төсөл	Хуулийн төслийн “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал” зүйлд хамаарах зарчмын зөрүүтэй саналыг томъёолж ажлын хэсгийн хуралд танилцуулсан байна.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал зүйл)-ийг УИХ-ын хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, хуулийн төслийн 23 дугаар зүйл буюу “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал” зүйлд санал өгч, сайжруулан хамтарч ажиллалаа. Боловсролын салбар	1-р сар, 2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					дахь хүүхэд хамгаалал зүйлд: сургалтын байгууллагын орчин, дотуур байранд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ; үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ; эцэг, эх, боловсролын байгууллагын талуудын үүрэг оролцоо; боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний үүрэг, оролцоо зэргийг тодорхойлж, нарийвчилсан зохицуулалтуудыг орууллаа. УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлж тайлбар мэдээлэл болон судалгааны үр дүнг нэгтгэн бэлтгэж, оролцлоо. Хавсралт: 1 файл		
8	ЕБС-ийн хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр боловсруулж,	Батлагдсан тушаал	БШУ-ны сайдын 2022 оны А/288 дугаар тушаал	Үлгэрчилсэн хөтөлбөр батлуулсан байна.	УИХ-ын 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай	1-р сар, 2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	батлуулна				хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/26 дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөр"-ийг батлуулав. Уг үлгэрчилсэн хөтөлбөрт 8 тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, бага, дунд, ахлах ангид хичээлээс гадуурх, сургалт, үйл ажиллагаагаар эзэмшүүлэх ур чадварыг зааж, суралцагчийн сайн дурын үндсэн дээр тэдний сонирхол, хэрэгцээ, багшийн ур чадвар, хүний нөөц, орон нутгийн онцлог зэргийг харгалзан сургууль эсхүл нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагыг түшиглэн суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтийн оролцоотой зохион байгуулах зохицуулалтыг тусгалаа. Үүнд: 1) хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжих, үүрэг оролцоог гэр бүлийн хүрээнд	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	-----------	--	--	--	--	---

					нэмэгдүүлэх, хэрэгжүүлэхэд хамтрах үйл ажиллагаа 2) эрүүл, аюулгүй амьдрах арга ухаанд сургах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх үйл ажиллагаа 3) бие бялдар, авьяас чадвар хөгжүүлэх үйл ажиллагаа 4) мэдээллийн технологийн ёс зүйтэй хэрэглээг дэмжих үйл ажиллагаа 5) суралцагчдын нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагаа 6) хувь хүний хөгжлийг дэмжих, дэлхийн иргэн байх ур чадвар эзэмшүүлэх 7) эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих 8) байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан. Түүнчлэн уг үлгэрчилсэн хөтөлбөрийн хавсралтад сургууль, дотуур байранд хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагааны загвар хөтөлбөрийг боловсруулж өгсөн нь сургуулийн багш,		
--	--	--	--	--	--	--	--

					ажилтнуудад арга зүйн дэмжлэг болох юм. Хавсралт: 2 файл		
9	Иргэний эрүүл мэндийн боловсролын дээшлүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангана.	Арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилт	-	Арга хэмжээ, төлөвлөгөө батлагдсан байна.	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2024-2027/-г Эрүүл мэндийн сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/75, А/09, А/73, А/34 дүгээр хамтарсан тушаалаар батлууллаа. Уг арга хэмжээний төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд боловсролын салбартай холбогдох 30 арга хэмжээний 10 нь гүйцэтгэхээр, 20 нь хамтран гүйцэтгэх арга хэмжээ байна. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

3.1. Төрийн албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж, хамтран ажиллах

10	Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу иргэд, албан тушаалтан, төр,	Албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайлан	-	Албан бичиг, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, хариу өгсөн байна.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан 19 өргөдөл, гомдол 24 албан бичгийг хуулийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын
----	---	---	---	---	--	--	--

	төрийн бус байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, хүсэлт, санал гомдлыг шийдвэрлэх, хуулийн хугацаанд хариу өгнө.				тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, хугацаанд нь хариу өгсөн байна. Нийт өргөдлийн 31,5 хувь нь хүүхдээс хандив, хураамж авсан талаар, 31 хувь нь багшийн ёс зүй харилцаа хандлага, 15,7 хувь нь суралцагчийн элсэлт, төгсөлт, сурах эрхтэй холбоотой өргөдөл, гомдол эзэлж байна.	сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
11	Удирдах албан тушаалтан, холбогдох байгууллагаас шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл, судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгнө.	мэдээлэл, судалгааны тоо	-	Мэдээлэл, судалгааг шуурхай, чанартай тайлагнасан байна.	Төр болон төрийн бус байгууллага болон удирдлагаас шаардсан мэдээлэл, тайланг тухай бүр хугацаанд нь гаргаж хүргүүлж ажиллалаа. Үүнд: 1.Улсын Их Хурлын 2022 оны 49 дүгээр тогтоол, 2023 оны 35 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд боловсролын салбарт хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл, танилцуулга /PPT/ бэлтгэн УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэв. Байнгын хорооны хуралд Боловсрол, шинжлэх ухааны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батцэцэг оролцож, мэдээлэл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хийсэн. 2.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан хэлэлцүүлэгт “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал”-ийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг /РРТ/ ТНБД-д бэлтгэж өгөв. 3.ЗТХЯ-ны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан 2 удаагийн хэлэлцүүлэг, уулзалтад оролцох Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд болон Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын даргад тус тус мэдээлэл бэлтгэн өгөв. 5.Японы Хүүхдийг Ивээх Сангаас гамшиг онцгой байдлын үед ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч буй хүүхдүүдэд тусламж үзүүлэхтэй холбоотой мэдээлэл, судалгааг гаргаж ОБЕГ-т хүргүүллээ. 6.Хүн амын сангаас зудад өртсөн 17 аймгийн 92 сумын дотуур байрны 4000 охидод ариун цэврийн хэрэгсэл /нэг бүрийн үнэ		
--	--	--	--	--	---	--	--

					16500, 230,000 төгрөг/-ийн багц хүргэх ажлыг зохион байгуулж, мэдээлэл, судалгаа гарган, нийгмийн ажилтан, дотуур байрны багш, эмч нарт сургалт хийлээ. 7.Нийгмийн шударга ёсыг бэхжүүлєе, хүүхдийн хөдөлмөрийг устгая бодлогын зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, биелэлт, явыг тайланг хугацаанд нь гаргаж хүргүүллээ. Хавсралт: 3 файл		
12	Төр болон төрийн бус байгууллага иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллаж, зөвлөгөө, мэдээлэл өгнө.	Тайлан, зөвлөгөө, мэдээлэл	-	Шаардлагатай тайлан, мэдээллийг цаг хугацаанд нь боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	Төр болон төрийн бус байгууллага иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр дараах хүрээнд хамтран ажиллалаа. Үүнд: - Гүүд Нэйрборс төрийн бус байгууллагатай хамтран “Хүүхдийн эрх”-ийн интерактив контент, комик ном бүтээх ажлыг удирдлага, чиглэлээр хангаж ажиллалаа. 6-10 насны хүүхдэд хүүхдийн эрхийн мэдлэг ойлголтыг тэдний нас, хөгжлийн онцлогт тохирсон интерактив хэлбэрээр	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хүргэхээр бэлтгэж, Монгол, Казак, Тува, Англи хэл болон дохионы хэлний орчуулгатайгаар www.medle.mn-д платформд байршууллаа. Уг контентыг суралцагч, эцэг эх, асран хамгаалагч болон олон нийтэд сурталчлан таниулах, хичээл, сургалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэхүүн болгон ашиглах боломж бүрдлээ. Түүнчлэн нэмэлтээр 2 контентыг боловсруулах ажлыг эхлээд байна. - Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэгтэй суралцагчдын эрсдэлийн үнэлгээний аргачлал, удирдамж боловсруулахад хамтран ажиллах талаар санал солилцож, удирдамж боловсрууллаа. - Equity Lab ТББ-тай хамтран “After school” цахим системд суурилсан хөтөлбөрийг эхлүүллээ. Уг хөтөлбөр нь 8 чиглэлийн 30 төрлийн хичээлээс сонгон сургалт, үйл ажиллагаанд хамрагдах		
--	--	--	--	--	---	--	--

					боломжтой юм. - Орбис Интернэйшнл ОУБ-тай хамтран хүүхдийн нүдний эрүүл мэндийг дэмжих зорилгоор 33 цэцэрлэг, сургуульд нүд, шүдний эрт илрүүлгийг зохион байгуулахаар төлөвлөж байна. Хараа шалгах аргачлалыг боловсролын байгууллагад нэвтрүүлэн цэцэрлэг, сургуулийн бүлгийн болон анги удирдсан багш, эмч, нийгмийн ажилтнаар удирдуулан нүдний илрүүлэг үзлэг хийж, ESIS системд цахимаар бүртгэх юм. - Боловсрол, шинжлэх ухааны газрын дотуур байрны асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд багшийн мэргэжлийн хөгжлийн бодлого чиглэл, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, үзэл баримтлалыг танилцуулах, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, агуулга, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг Боловсролын ерөнхий газартай хамтран зохион байгууллаа. - Дотуур байрны багш, сургуулийн эмчийг чадавхжуулах 2	
--	--	--	--	--	---	--

					удаагийн сургалтыг Боловсролын ерөнхий газрын мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулж, сургалт бүрд илтгэл, мэдээлэл хийж оролцов.		
13	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг “Хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулна.	Нэгжийн хөтлөх хэргийн жагсаалт/ архивын нэгжийн тоо	Хөтлөх хэргийн жагсаалтын дагуу архивт хүлээлгэж өгсөн хадгаламжийн нэгжийн тоо	Хөтлөх хэргийн жагсаалтын дагуу архивт хүлээлгэж өгсөн хадгаламжийн нэгжийн тоо	Эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах “Боловсролын орчин дахь хүүхэд хамгаалал-2023” судалгааны тайланг “Хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу хадгаламжийн нэгж болгон архивт хүлээлгэн өгөв. Уг судалгаагаар, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 27,2 хувь буюу 4 суралцагч тутмын 1 нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд сургуулийн орчинд /сургуулийн коридор, анги, хичээлийн танхим, ариун цэврийн өрөө, биеийн тамирын заал гэх мэт хүүхэд олноор цуглардаг газар/ аюулгүй байдал алдагдсан, 38,8 хувь буюу 5 суралцагч тутмын 2 нь сургуульд ирж, буцахдаа ямар нэг тээврийн хэрэгслээр зорчдог, эмэгтэй суралцагчдын 64.0 хувь нь сургуульдаа ирж, буцахдаа гэрлэн	2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					дохионы ажиллагаагүй байдал, халтиргаатай зам, гэрэлтүүлэггүй гудамж, архи уудаг хүмүүс цуглардаг газар, нохой, автомашины хөдөлгөөнөөс эмээх зэрэг саад бэрхшээлтэй тулгардаг, 3 суралцагч тутмын 1 нь сургууль дээрээ үе тэнгийнхний дээрэлхэлтэд өртөж байсан гэсэн үр дүн гарсан талаар тайланд тусгагдсан. Хавсралт: 1 файл		
14	Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, үнэлэх	Төлөвлөгөө, тайлан	-	Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, тайлагнасан байна.	Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт суурилан боловсруулж батлуулж, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг цаг тухайд нь гаргаж ажиллалаа. Төлөвлөгөөнд тусгагдсанаас гадна дараах ажлыг хийж гүйцэтгэлээ: 1. Боловсролын шинэ зууны сэргэлт арга хэмжээний ойн лого, энгэрийн тэмдэг, бэлэг,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					дурсгалын зүйлсийг сонгох, хэвлүүлэх, худалдан авах, гардуулах ажлыг зохион байгуулах ажлыг Ж.Мягмар даргаар ахлуулсан дэд баг хийж гүйцэтгэлээ. Ажлын хэсгийн гишүүд багийн зохион байгуулалтад орж, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хариуцан гүйцэтгэх албан хаагчийг хуваарилан, холбогдох ажлуудаа цаг хугацаанд нь дуусгалаа. 2. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01 дугаар тогтоолоор батлагдсан "Үндэсний зөвлөлийн дүрэм"-ийг тус яаманд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 03/07 тоот албан бичгээр ирүүлсэн. Уг дүрэмд яам бүр дэргэдээ "Хүүхдийн төлөө дэд зөвлөл"-тэй байхаар заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны яамны дэргэд ажиллах хүүхдийн төлөө дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах	
--	--	--	--	--	---	--

					БШУ-ны сайдын тушаалын төслийг боловсруулан, нэгжийн дарга нарт танилцуулж байна. Түүнчлэн уг дүрэмд нийцүүлэн дэд зөвлөлийн ажиллах үйл ажиллагааны дүрмийн төслийг боловсрууллаа. 3. Дархан, Сэлэнгэ, Төв аймагт Боловсролын багц хуулийг сурталчлан таниулах, тэдгээрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх сургалт зохион байгуулах багт 2024 оны 4 дүгээр сарын 1-7-ны хооронд ажиллав. Уг сургалтад ерөнхий боловсролын сургууль,, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, ҮЭ-ийн хороо, бүлгийн дарга нар хамрагдаж, Боловсролын багц хууль, салбарын бодлого, эрх зүйн шинэчлэлийн талаар нэгдсэн мэдээлэлтэй болж, орон нутагт хэрэгжүүлэх чадавхаа бэхжүүлэв.		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	БШУЯ болон мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдана.	сургалт	-	БШУЯ болон мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдсан байна.	Төрийн албаны зөвлөл болон тус яамнаас зохион байгуулсан дараах сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа ахиуллаа. Үүнд: 1.“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч зөрчихөөс урьдчилан сэргийлэх нь”; 2.Хүний эрх, хамгаалагчийг хамгаалах механизмын үйл ажиллагаа; 3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал; 4.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг танилцуулах; 5.”Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-II” зохион байгуулах тухай 6.Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага”; 7.”Дижитал шилжилт, виртуал орчинд ажиллах” 8.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”; 9.Хорин нэгдүгээр зууны боловсрол Насан туршийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					суралцахуй” сэдэвт сургалтуудад танхимаар болон цахимаар хамрагдаж, өөрийн ур чадвар, мэдлэг, ойлголтоо нэмэгдүүллээ.		
2	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, ажлын чиг үүрэгтэй холбоотой ном, гарын авлагыг судална.	Судалсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, ном, гарын авлага	-	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, ажлын чиг үүрэгтэй холбоотой ном, гарын авлагыг судалсан байна.	Монгол Улсын Их хурлын 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн чуулганаар батлагдсан Боловсролын ерөнхий хууль болон Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийг судалж, Дархан, Сэлэнгэ, Төв аймагт Боловсролын багц хуулийг сурталчлан таниулах, тэдгээрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх сургалт зохион байгуулах багт 2024 оны 4 дүгээр сарын 1-7-ны хооронд ажиллав. Түүнчлэн УИХ-ын 2024 оны 1 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон бусад хууль, тогтоомжийг судалж, эрхэлсэн ажилдаа тусган ажиллаж байна. Түүнчлэн "Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал-2023", "Дотуур байрны өнөөгийн байдал, хүчин чадлыг тодорхойлох судалгаа" зэрэг үндэсний 2 судалгааг зохион байгуулах багт ажиллаж, ном, гарын авлагыг судлав. БШУЯ, БСҮХ, БЕГ, БҮТ-өөс хамтран зохион байгуулсан “Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл арга зам-2024” эрдэм шинжилгээний хуралд оролцож, мэдлэг, ур чадвараа ахиуллаа. Уг хурлаар сургуулийн	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, боловсролын бодлогын хэрэгжилт, зарим үр дүн болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын аз жаргалтай сайн сайхан байдал, сэтгэл хөдлөлийн чадамж зэрэг үндсэн илтгэлүүдийг хэлэлцүүлсэн 5 салбар хуралдаан боллоо. Хавсралт: 4 файл		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч, Батсуурь Дуламсүрэн
/...../ Огноо: